

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 30 өдрийн 10 цагаас цахим хэлбэрээр зохион байгууллаа. Компанийн 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 04 тоот тогтоолоор томилсон хурлын дарга, гүйцэтгэх захирал С.Сайнбат, тооллогын комиссын дарга, тооцооны нягтлан бодогч Ж.Пүрэвжаргал, гишүүд өмгөөлөгч Э.Батбаяр, өмгөөлөгч Н.Цагаанхүү нарын бүрэлдэхүүнтэйгээр хурлын үйл ажиллагааг зохион байгуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард тусгасны дагуу хурлаас өмнө компанийн байранд ирж мэйл хаягаа бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдэд цахимаар хийх хурлын заавар, цахим хуралд нэвтрэх нууц үгийг баталгаат мэйлээр илгээн, бүртгэгдэн мэйлээс хандалт хийснээр хурлын ирцийг бүртгэх ажлыг тооллогын комисс 9:30 цагаас 10:00 цаг хүртэл хийлээ.

Хурлын үйл ажиллагааг 10:00 цагт эхлэв.

Хурлын дарга С.Сайнбат: Миний бие “УИД” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг бөгөөд компанийн ТУЗ-ийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийх, хурлыг даргалах үүргийг надад өгсний дагуу өнөөдрийн хурлыг би даргалан, зохион байгуулж явуулна. Өнөөдрийн хурлыг “Zoom” аппликейшн ашиглан явуулж байгаа ба хүмүүсийн микрофоныг хаасан байгаа, та бүхэнд асуулт байгаа бол чат ашиглах буюу, хурлын админд хандан микрофоноо нээлгэж сонирхсон асуултаа асуугаарай. Хурлын админ хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултыг нэгтгэн надад ирүүлж байгаа, мөн хуралд хандан оролцогчдын мэдээлэл, мэйл хаяг, асуулт, хандалтын тоо, тооллогын комиссын дүн зэргийг бүгдийг хувьцаа эзэмшигчдэд харагдах байдлаар дэлгэцэд тохируулж, баталгаажуулах үүднээс бичлэг хийж байна. Бид бичлэгийг Санхүүгийн зохицуулах хороо зэрэг эрх бүхий байгууллагуудад хүргүүлнэ. Хувьцаа эзэмшигч та бүхэн хороонд хүргүүлсэн бичлэгийг шаардлагатай тохиолдолд хандан авах боломжтой.

Одоо та бүхэнд Тооллогын комиссын тогтоол №01 уншиж танилцуулъя.

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2, 67.3.8, 68.4 дахь хэсэг болон цахим хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн хандалтын ирцэд тус тус үндэслэн тогтоох нь:

“УИД” ХК-ийн саналын эрхтэй нийт 36,807,850 ширхэг хувьцаанаас 26,129,134 ширхэг хувьцаа буюу 70,99%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хандалт хийн энэ хуралд оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцугай. гэжээ.

Хувьцаа эзэмшигч та бүхэнд хурлын танилцуулга материалыг мэйлээр хүргүүлэх, биеэр ирж бүртгүүлэх үед цаасан хэлбэрээр тараасан байгаа. Танилцуулга материалыг Улсын онцгой комиссын тогтоол гарч, өндөржүүлсэн бэлэн байдал зарлахаас өмнө хэвлүүлэн тараасан байсан. Өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас хурлыг цахимаар хийж байгаатай холбоотой хурлын дэгд өөрчлөлт орсон. Цахим хурлын дэг ёсоор хэлэлцүүлэх асуудлаа эхлээд дарааллын дагуу танилцуулаад, хувьцаа эзэмшигчдийн ирүүлсэн асуултанд хариулах байдлаар явуулъя. Мөн хувьцаа эзэмшигч та бүхэн танилцуулгын үед чатаар асуултаа илгээж болно. Микрофон нээлгэх хүсэлтээ бас чатаар илгээж болно. Бүгдийг зэрэг нээх буюу байнга нээлттэй байлгах боломжгүй байна. Шалтгаан нь дуу чимээтэй орчинд байгаа хүмүүсийн дуу чимээ давхардан орж ирэх, үг яриа давхардах зэргээр хүндрэл гараад байгааг та бүхэн ойлгоорой.

Танилцуулгад зарын дагуу 10 хүн нэр дэвшиж өөрийн анкет материалаа ирүүлсэн гээд нэр дэвшигчдийг нэг бүрчлэн уншиж танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/.

- | | |
|-------------------------------|------------------------------|
| 1. Шагдарсүрэнгийн Баярсайхан | 6. Бат-Очирын Бямба-Оров |
| 2. Балдандоржийн Ариунжаргал | 7. Лутбаярын Чулуунбаатар |
| 3. Сэнгэдоржийн Хосбаяр | 8. Дашдондогийн Дашцэдэн |
| 4. Алтангэрэлийн Норсмаа | 9. Намсрайн Батцацрал |
| 5. Янсанжавын Наваан | 10. Өлзийбүрэнгийн Үнэнбүрэн |

Хэлэлцэх асуудлын танилцуулга дууслаа. Компани 2019 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэсэн байгаа. Шалтгаан нь өмнөх онуудын алдагдлаа нөхөж чадаагүй байгаатай холбоотой. Ногдол ашиг хуваарилсан эсэх тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар хуульчилсан тул та бүхэнд танилцуулж байна. Одоо асуулт хариултаа эхэлье.

Асуулт№01: ulzii@bdsec.mn /Би Ди Сек ХК-ийн төлөөлөл А.Өлзиймаа /: Яриа сонсогдохгүй байсан тул сонсож чадсангүй. Ирцийн мэдээллээ дахин өгнө үү?

Хариулт: Хуралд 26,130,437 ширхэг хувьцаатай хувьцаа эзэмшигч буюу ирцийн хувь 70,99% байна. Урьдчилан санал өгсөн 26 хувьцаа эзэмшигч буюу 1,831,884 ширхэг хувьцаатай хувьцаа эзэмшигч, онлайнаар 24,298,553 ширхэг хувьцаатай хувьцаа эзэмшигчид хандалт хийсэн учир хурлын ирц хангагдаж хүчин төгөлдөр болсон гэж тооллогын комисс үзсэн байна.

Асуулт№02: ulzii@bdsec.mn /Би Ди Сек ХК-ийн төлөөлөл А.Өлзиймаа/: Хурлын батлагдсан тогтоолын хуулбарыг ирүүлэх боломжтой уу?

Хариулт: Болно. Мэйлээр бид хуралтай холбоотой бичиг баримт мэдээллийг хүргүүлнэ.

Хурлын дарга С.Сайнбат: Хурлын дэгд заасны дагуу асуулт хариултын цаг дуусч байна. Та бүхэн асуух зүйлээ чатаар бичээрэй. Та бүхэнд чатаар илгээсэн "Google form" линкээр орж хувьцаа эзэмшигч та бүхэн саналаа өгөөрэй. /Санал хураалтын талбарт ажиллах зааварчилгаа өгч цаг тоолж эхлэв. Санал хураалтын хугацаа 20 минут/ Санал хураалт 11 цаг 15 минутад өндөрлөж, саналын дүнг нэгтгэж эхлэв. Тооллогын комисс 11 цаг 35 минутанд санал хураалтын дүнг нэгтгэж дуусаад танилцуулав.

Хурлын дарга С.Сайнбат: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үргэлжилж байна. Санал хураалтын дүнг нэгтгэсэн Тооллогын комиссын тогтоол №02 уншиж танилцуулья.

КТХ-ийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг танилцуулав.

Нийт саналын эрхтэй хувьцааны тоо ширхэг - 36,807,850

Саналын эрхтэй хувьцааны тоо - 26,130,437

Урьдчилан ирүүлсэн саналын хуудас 26, хувьцааны тоо 1,831,884 ширхэг

1. "Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай" санал хураалтын дүн:

- 1.1. Зөвшөөрсөн - 26,130,139 ширхэг буюу 99,999 % ;

- 1.2. Татгалзсан - байхгүй ;

- 1.3. Түдгэлзсэн - байхгүй ;

- 1.4. Санал өгөөгүй /хүчингүй/- 298 ширхэг буюу 0,001%

2. "Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг батлах тухай" санал хураалтын дүн

- 2.1. Зөвшөөрсөн - 26,130,139 ширхэг буюу 99,999 %;

- 2.2. Татгалзсан - байхгүй ;

өөрчлөлтийг батлах тухай", Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №04 тоот "Компанийн эд хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэх тухай", Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №05 тоот "Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай" тогтоолуудыг танилцуулж, 11 цаг 35 минутанд хурлын үйл ажиллагааг хаав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА В.ХҮРЭЛХАД

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА..... С.САЙНБАТ

